ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ-ын
2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн
IV Чуулганы 19/06 дугаар тогтоолоор батлав.
9071001143
2020 04 15

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ-ЫН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Дүрмийн зорилго нь “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /цаашид “Ассоциаци” гэх/-ийн эрхэм зорилго, үйл ажиллагааны зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэл, бүтэц, зохион байгуулалт, тэдгээрийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж зохицуулахад оршино.

1.2. Ассоциаци нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрэм болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах, Монголын барилга, хот байгуулалт, үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбар /цаашид “салбар” гэх/-ыг хөгжүүлэх, гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилго бүхий сайн дурын, гишүүддээ үйлчилдэг, ашгийн бус, мэргэжлийн төрийн бус байгууллага мөн.

1.3. Ассоциацийн оноосон нэр:

1.3.1. Монгол хэлээр: “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ, товчилсноор “МБҮА”,

1.3.2. Англи хэлээр: “Mongolian National Construction Association” товчилсноор “MNCA”,

1.4. Ассоциацийн /байршил: Монгол Улс, Улаанбаатар 15141, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж 24, МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот.

1.5. 2009 оны 04-р сарын 06-ны өдрийг МБҮА ТББ буюу Ассоциацийг үүсгэн байгуулсан өдөрт тооцно.

1.6. Ассоциаци нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

1.7. Ассоциаци нь гишүүн байгууллагатай хамтран нийгмийн сайн сайхны төлөө нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулж болно.

1.8. Ассоциацийн Удирдах зөвлөлийн гишүүн, Хяналтын зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгчдийг сонгох сонгуулийн санал хураалт, Ассоциацийн дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал хураалтыг шинэ технологи хэрэглэн цахимаар явуулж болно.

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ
ХТА2020 ⊕ 8002541

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ, ЧИГЛЭЛ

2.1. *Алсын хараа:* Гишүүн байгууллагуудынхаа ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалж төлөөлсөн, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, барилга, хот байгуулалт, үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын манлайлагч, мэргэжлийн байгууллага байна.

2.2. *Эрхэм зорилго:* Барилга, хот байгуулалт, үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбарт сайн засаглалыг бий болгоход төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдааг сайжруулж, хууль эрх зүйн орчинд шинэчлэл хийхэд нөлөөлж, гишүүдийн чадавхыг сайжруулан барилгын зах зээлийн тогтвортой өсөлтийг хангахад хувь нэмрээ оруулахад оршино.

2.3. *Ассоциацийн зорилго*:

2.3.1. Гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалж, төлөөлж ажиллах;

2.3.2. Гишүүдийн чадавхыг сайжруулах, тэдний хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.3.3. Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдааг хангах, салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлоход оролцож салбарт сайн засаглалыг бий болгон хөгжүүлэх;

2.3.4. Салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, боловсронгуй болгоход төр, засагт дэмжлэг үзүүлэн хууль, эрх зүйн акт, норм, стандартыг боловсруулахад оролцох, салбарт олон улсын гэрээний зарчмыг нэвтрүүлэх;

2.3.5. Салбарын хөгжил, компаниудын өрсөлдөх чадвар, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулах, салбарын судалгаа хөгжлийг дэмжиж тэргүүний технологийг нэвтрүүлэх замаар барилгын үйлдвэрлэлийн менежмент, чанарыг шинэ төвшинд гаргах;

2.3.6. Барилгын зах зээлийг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.3.7. Салбарын үйл ажиллагааг дотоодод болон олон улсад таниулан, сурталчлах;

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН БАРИЛГЫН УЙДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ
ХТА2020 8002541

2.3.8. Ассоциацийн тогтвортой үйл ажиллагаа, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх,

2.3.9. Барилгын салбарын төрийн зарим чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр гэрээгээр гүйцэтгэх,

2.4. Ассоциацийн үйл ажиллагааны зарчим:

2.4.1. Улс төрийн болон шашны үйл ажиллагаанаас татгалзах;

2.4.2. Ассоциацийн гишүүдийн эв нэгдэл, нэгдмэл бодлого, нэгдсэн байр суурийг эрхэмлэх;

2.4.3. Ассоциацийн засаглал, үйл ажиллагаа нь ардчилсан, шударга, нээлттэй, ил тод байж гишүүд хоорондын болон харилцагч байгууллага, нийгмийн олон талт хамтын ажиллагаанд харшлахгүй байх;

2.4.4. Ассоциацийн ажлын үр дүнг гишүүддээ эргэж тайлагнадаг байх;

2.4.5. Ассоциацийн гишүүд нээлттэй хэлэлцүүлэг, хамтын шийдвэрийг удирдлага болгох;

2.4.6. Аливаа хувь хүн, хуулийн этгээд, ямар нэгэн бүлгийн явцуу ашиг сонирхлыг илэрхийлэхгүй, хөхүүлэн дэмжихгүй байх.

2.5. Ассоциацийн үйл ажиллагааны үндсэн чиглэл:

2.5.1. Барилга, хот байгуулалт, үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн төсөлд санал өгөх;

2.5.2. Ассоциацитай холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж, шаардлагатай үед байр сууриа илэрхийлсэн мэдэгдэл гаргах;

2.5.3. Төрөөс хот байгуулалт, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө, барилгын салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах, бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн санал, санаачлалыг гаргах;

2.5.4. Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын төрийн бус байгууллагад гишүүнээр нэгдэн орох, ижил зорилго бүхий өөрийн орны төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

2.5.5. Барилгын салбарын тэргүүлэх мэргэжилтнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, Ассоциацийн гишүүд, салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулж, тэднийг тасралтгүй хөгжих бололцоог бий болгох;

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ
ХТА/020 @ 8002541

2.5.6. Барилгын салбарын ажилтан, ажилтнуудын нэр хүндийг дээдэлж, ахмад болон залуу үеийн холбоог бэхжүүлэх, хамтарч ажиллах, салбарын ажил, үйлчилгээтэй холбоотой гишүүдийн санал бодлыг төр засагт хүргэх, эрх ашгийг нь хамгаалах;

2.5.7. Гишүүдийн мэдээллийн сантай болох, салбарын хууль тогтоомж, норм дүрэм, хөгжлийн мэдээллийг гишүүддээ түгээх, мэдээллийн олон сувагтай байж, ил тод байх;

2.5.8. Мэргэжлийн чиглэлээр төрөл бүрийн сургалт, уралдаан, шалгаруулалт зохион байгуулах, зуучлах, үр дүнг нь сурталчлах, Үндэсний болон олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэн, яармаг худалдаа, зөвлөгөөн зэрэг бусад арга хэмжээг зохион байгуулах, оролцох;

2.5.9. Төрийн захиргааны төв байгууллагаас эрх шилжүүлсэн төрийн зарим чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд гэрээгээр гүйцэтгэх;

2.5.10. Ассоциаци нь жил бүр стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үйл ажиллагаандаа чиглэл болгон төлөвлөж ажиллах ба жил бүрийн үйл ажиллагаа нь тухайн жилийн төлөвлөгөөний хүрээнд нарийн зохион байгуулагдаж, төлөвлөгдөж олон нийтэд нээлттэй байдлаар явагдах;

2.5.11. МБҮА ТББ-ын гишүүн байгууллагуудын дунд хүний нөөцийн тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр судалгаа, мэдээллийн сантай болох.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

3.1. Ассоциаци нь өөрийн хөрөнгө, бие даасан тайлан тэнцэлтэй байх бөгөөд банканд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй.

3.2. Ассоциаци нь өөрийн үйл ажиллагааны онцлогийг харуулсан бэлгэ тэмдэг, бэлгэдэл, далбаа, албан бичгийн хэвлэмэл хуудас, цахим хуудас, өөрийн нэрэмжит шагналтай байна.

3.3. Ассоциаци нь орон нутагт болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах, олон улсын байгууллага, холбооны гишүүн байх эрхтэй.

3.4. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй тохиолдолд Ассоциацийн үйл ажиллагаанд төрийн, төрийн бус болон бусад байгууллагууд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ

3.5. Ассоциаци нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд хүлээсэн үүргийг өөрийн хөрөнгөөрөө хариуцна. Гишүүдээс Ассоциацийн мэдэлд шилжүүлсэн эд хөрөнгө нь түүний өмч байна.

3.6. Ассоциацийн зүгээс дотоодын болон гадаадын хуулийн этгээдтэй хамтрах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих эрх нээлттэй ба уг үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдсэн олон улсын гэрээ, конвенцын хүрээнд явуулна.

3.7. Ассоциаци нь өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагааныхаа зорилгод нийцсэн гэрээ, хэлцэл байгуулах, эд болон эдийн бус хөрөнгө, эрхийг олж авах, захиран зарцуулах эрхтэй.

3.8. Ассоциаци нь өөрийн зорилго, үйл ажиллагаа, ашиг сонирхолд нэгдсэн дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах, төрийн бус байгууллага, эвсэл, холбоонд гишүүнээр элсэх, ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд тэднээр төлөөлүүлэх эрхтэй.

3.9. Ассоциаци нь орлого олох үйл ажиллагааны чиглэлээ Улсын бүртгэлийн гэрчилгээндээ тусгасан байна.

3.10. Ассоциаци нь өөрийн хэвлэлтэй байж болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙН ГИШҮҮНЧЛЭЛ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1. Ассоциацийн гишүүнчлэл:

4.1.1. Ассоциацийн эрхэм зорилго, зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэл, гишүүнчлэлийн журмыг хүлээн зөвшөөрсөн барилга, хот байгуулалт, үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд, тэдгээртэй харилцагч, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг дотоод, гадаадын байгууллага нь Ассоциацийн гишүүн байна.

4.1.2. Удирдах зөвлөл нь Ассоциацийн гишүүнчлэлийн журмыг батлах ба энэхүү журмаар Гишүүнчлэлийн бодлого, зэрэглэл, эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулна.

4.1.3. Гишүүн нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.1.3.1. Эрх ашгаа хамгаалуулах, Ассоциацийн үйл ажиллагааны талаарх санал хүсэлтээ зохих журмын дагуу илэрхийлэх, шийдвэрлүүлэх, шинэ ажил санаачлан дэмжүүлэх эрхтэй.

4.1.3.2. Чуулганд Гишүүнчлэлийн журамд заасны дагуу гишүүд нь саналын эрхтэйгээр оролцож Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, сонгогдох, Ассоциациас байгуулах Ажлын хэсэгт томилогдон ажиллах эрхтэй.

4.1.3.3. Тогтоосон тооны бусад гишүүдтэй хамтарч Чуулганд болон Удирдах зөвлөлийн хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх эрхтэй.

4.1.3.4. Ассоциациас зохион байгуулж байгаа арга хэмжээ, төслийг дэмжиж хандив өргөх эрхтэй.

4.1.3.5. Ассоциациас зохион байгуулагдаж буй аливаа үйл ажиллагаа, сургалт, семинарт Гишүүнчлэлийн журамд заасан нөхцөлөөр хамрагдах эрхтэй.

4.1.3.6. Ассоциацийн танилцуулга, цахим хуудсанд өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл тавих, түүгээр дамжин бусад байгууллага, хэрэглэгчидтэй харилцах, гадаад, дотоодод үйл ажиллагаагаа сурталчлах эрхтэй.

4.1.3.7. Ассоциацийн үйл ажиллагааны талаарх холбогдох дэлгэрэнгүй мэдээ, мэдээллийг авах эрхтэй.

4.1.3.8. Гишүүнчлэлийн журмын дагуу гишүүнчлэлийн татвараа хугацаанд нь төлөх үүрэгтэй.

4.1.3.9. Ассоциацийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах үүрэгтэй.

4.1.3.10. Удирдах зөвлөл болон Ерөнхийлөгчдийн зөвлөлөөс баталсан журам, дүрэм, тогтоол, шийдвэрийг дагаж мөрдөхийн зэрэгцээ Ассоциациас зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд идэвхтэй оролцож, үйл ажиллагааг нь дэмжих үүрэгтэй.

4.1.3.11. Ассоциацийн бусад гишүүдийг хүндэтгэж, тэгш эрхтэй харилцах, Ассоциацийн нэр хүнд, үзэл баримтлалд сөргөөр нөлөөлөх, үл хүндэтгэсэн, ёс зүйгүй аливаа үйлдлийг гаргахгүй байх үүрэгтэй.

4.1.3.12. Ассоциацийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, шийдвэрийг хэрэгжүүлэхэд биечлэн оролцож, өөрийн хувь нэмрээ оруулах үүрэгтэй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ГИШҮҮНЭЭС ХАСАХ

5.1. Ассоциацийн гишүүнээр бүртгэх:

5.1.1. Ассоциацийн гишүүнээр элсэхийг хүсэгч нь Ассоциацийн Гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх бөгөөд Ассоциацийн цахим хуудсанд байршуулсан Гишүүний бүртгэлийн маягтыг үнэн зөв бөглөж гишүүнээр бүртгүүлнэ. Бүртгэгдсэн гишүүнийг Ассоциацийн эрхэм зорилго, зорилт, зарчим, энэхүү дүрэм, Гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

5.1.2. Гишүүнээр бүртгүүлэгч нь Гишүүнчлэлийн журамд заасан материалыг бүрдүүлж Ажлын албанд өгнө.

5.1.3. Ассоциацийн гишүүнээр бүртгүүлэгчийн материалыг Ажлын алба нь судалж Гишүүнчлэлийн журамт нийцсэн бол Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, гишүүний гэрчилгээг гардуулна.

5.2. Ассоциацийн гишүүнээс хасах:

5.2.1. Дараах тохиолдолд Ассоциацийн гишүүнээс хасаж, холбогдох бүртгэлийн өөрчлөлтийг Ажлын алба нь ажлын 5 /тав/ хоногт багтаан хийх ба энэхүү өөрчлөлтийг гишүүдэд мэдээлнэ. Үүнд:

5.2.1.1. Гишүүн өөрөө гишүүнчлэлээс гарах хүсэлтээ бичгээр гаргасан;

5.2.1.2. Ассоциацийн үйл ажиллагаанд идэвхгүй оролцсон, хүндэтгэх шалтгаангүйгээр оролцохоос удаа дараа зайлсхийсэн гэсэн дүгнэлтийг Удирдах зөвлөл гаргасан;

5.2.1.3. Үйл ажиллагаа нь татан буугдсан, дампуурснаас шалтгаалан цаашид гишүүнээр байх боломжгүй болсон;

5.2.1.4. Ассоциацийн эрхэм зорилгыг үл хүндэтгэсэн, ашиг сонирхлын зөрчлөөр хандсан, гишүүний ёс зүйд үл нийцсэн үйл ажиллагаа явуулсан нь Хяналтын зөвлөлийн дүгнэлтээр тогтоогдсон.

5.2.2. Гишүүн нь тухайн жилийн татвараа төлөөгүй бол гишүүний саналын эрхийг нь 6 сарын хугацаагаар түдгэлзүүлэх ба энэ хугацаанд шийдвэр гаргахад оролцохоос бусад Ассоциацийн үйл ажиллагаанд оролцох боломж нээлттэй байна.

Харин энэ хугацаанд татвараа төлөөгүй бол Ассоциацийн гишүүн байх эрх нь автоматаар цуцлагдана.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙН ЭРХ БАРИХ ДЭЭД БАЙГУУЛЛАГА

6.1. Ассоциацийн эрх барих дээд байгууллага нь Чуулган байна.

6.2. Чуулган нь Ээлжит болон Ээлжит бус байх ба Ээлжит чуулганыг 3 /гурав/-н жилд нэг удаа, Ээлжит бус чуулганыг Ассоциацийн гишүүдийн 1/3 /гуравны нэг/-ээс доошгүй хувийн санал эсвэл Хяналтын зөвлөлийн шаардсанаар Удирдах зөвлөлийн хурлаас зарлан хуралдуулна.

6.3. Чуулган хуралдуулах хугацаа, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Удирдах зөвлөлийн хурлаас баталж, чуулган эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө нийт гишүүдэд цахим мэдээллийн хэрэгслээр мэдэгдэнэ.

6.4. Улс орны хэмжээнд бий болсон онцгой нөхцөл байдал (байгалийн гамшиг, олон нийтийг хамарсан өвчин тахал, эдийн засгийн хямрал г.м.)-ын улмаас давагдашгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд он-лайнаар хуралдаж болно.

6.5. Чуулганаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

6.5.1. Ассоциацийн дүрмийг батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчилсэн найруулгыг батлах;

6.5.2. Ассоциацийн Удирдах зөвлөл, Ерөнхийлөгчид болон Хяналтын зөвлөлийн /гишүүдийн/ үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;

6.5.3. Ассоциацийн Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүдийг 3 жилийн хугацаагаар сонгох, чөлөөлөх;

6.5.4. Ассоциацийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг нийт гишүүдийн 3/4 /дөрөвний гурав/-аас доошгүй хувийн саналаар шийдвэрлэх;

6.5.5. Ассоциацийн стратеги төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

6.5.6. Чуулганд хэлэлцүүлэхээр санал нэгдсэн 30-аас доошгүй гишүүдийн тавьсан асуудал болон Удирдах зөвлөлийн хурлаас оруулсан бусад асуудал;

6.6. Чуулганаар хэлэлцэн шийдвэрлэх зарим чиг үүргийг Удирдах зөвлөлд шилжүүлж болно;

6.7. Саналын эрхтэй гишүүдийн ердийн олонх оролцсоноор Чуулганы хуралдаан хүчин төгөлдөр болох ба хэлэлцсэн асуудлаар саналын эрхийн ердийн

олонхоор гаргасан шийдвэр хүчин төгөлдөр болно. Гишүүдийн санал тэнцвэл дахин санал хураана.

6.8. Чуулганы хуралдаанаас чуулганы хуралдааны дэгийг тогтооно.

6.9. Тооллогын комиссын шийдвэрээс бусад чуулганы хуралдааны тэмдэглэл, шийдвэрийг Чуулган даргалагч баталгаажуулж гарын үсэг зурна.

6.10. Чуулганы хуралдааны бичиг хэргийг Ассоциацийн Ажлын алба хариуцан хөтөлж хадгална.

ДОЛДУГААР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

7.1. Чуулганы чөлөөт цагт Ассоциацийн эрх барих дээд байгууллага нь Удирдах зөвлөл байна.

7.2. Удирдах зөвлөл нь 35 /гучин тав/-н гишүүнээс бүрдэнэ.

7.3. Удирдах зөвлөлийн гишүүнийг Чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар 3 /гурав/ жилийн хугацаатай сонгоно.

7.4. Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь Ассоциацийн гишүүн байх бөгөөд Гишүүнчлэлийн журамд заасан нэр дэвших нөхцөл, шаардлагыг хангасан бол өөрийн танилцуулгыг чуулганы хуралдаанаас 7 /долоо/-оос доошгүй хоногийн өмнө Ажлын алба болон нийт гишүүдэд цаасаар эсвэл цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

7.5. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хэлбэр нь Хурал байх ба Удирдах зөвлөлийн хурал нь Ээлжит болон Ээлжит бус байна. Ээлжит хурлыг улиралд 1 /нэг/ удаа, Ээлжит бус хурлыг нийт гишүүдийн 1/3 /гуравны нэг/-ийн шаардлага болон саналыг үндэслэн тухай бүрд нь Ерөнхийлөгч зарлан хуралдуулна.

7.6. Удирдах зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудал, байршлыг Ажлын албанаас Хурал болохоос 7 /долоо/-оос доошгүй хоногийн өмнө Удирдах зөвлөлийн гишүүдэд мэдэгдэнэ.

7.7. Удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

7.7.1. Ассоциацийн бодлого, хэтийн төлөв, стратегийг тодорхойлох, стратеги төлөвлөгөөг боловсруулж чуулганаар хэлэлцүүлэх;

7.7.2. Чуулганы хуралдаанаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

7.7.3. Хяналтын зөвлөлийн зөвлөмж, шаардлагаар Ассоциацийн дүрэм, журам, бодлогын баримт бичгүүдийн хооронд зөрчилдөж, үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэсэн заалтуудыг хэлэлцэж шийдвэрлэх;

7.7.4. Ээлжит болон Ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлах;

7.7.5. Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, долоон /7/ Дэд ерөнхийлөгчийг Удирдах зөвлөлийн гишүүд дотроос 3 /гурав/-н жилийн хугацаагаар сонгох, чөлөөлөх, нөхөн сонгох;

7.7.6. Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нараас бүрдсэн Ерөнхийлөгчдийн зөвлөлийг байгуулж, түүний эрх хэмжээг тогтоох, үйл ажиллагааны журмыг батлах;

7.7.7. Ассоциацийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл хариуцсан Байнгын хороо, хөгжлийн тухайн үеийн нөхцөл шаардлагыг харгалзан Түр хороо байгуулах асуудлыг шийдвэрлэх, тэдгээрийн тоо, нэр, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх, татан буулгах;

7.7.8. Удирдах зөвлөлийн хурлаар салбарын хөгжлийн асуудлыг хэлэлцэхэд зөвлөх эрхтэй оролцож, мэргэжлийн зөвлөгөө өгөх Зөвлөх гишүүнийг томилох, чөлөөлөх;

7.7.9. “Байнгын хороо, Түр хорооны бүтэц, үйл ажиллагааны журам” “Гишүүнчлэлийн журам”, “Нэрэмжит шагнал олгох журам”, “Ажлын албаны Хөдөлмөрийн дотоод журам”, “Албан хэрэг хөтлөлтийн журам” болон бусад журмын төслийг хэлэлцэн батлаж мөрдүүлэх, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох;

7.7.10. Ассоциацийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг батлах, тайланг хэлэлцэж шийдвэр гаргах;

7.7.11. Чуулганы чөлөөт цагт Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, нөхөн сонгох асуудлыг Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар нийт гишүүдийн 1/3 /гуравны нэг/ хүртэл хувьд өөрчлөлт оруулан шийдвэрлэх;

7.7.12. Ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн хэмжээ, санхүүгийн зардлын төсвийг батлах, Ажлын албаны үйл ажиллагааг удирдлагын шийдвэрээр хангах;

7.7.13. Гүйцэтгэх захирлыг томилох, үүрэгт ажлаас чөлөөлөх, өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоох, түүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх;

7.7.14. Ассоциацийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд туслах мэргэжлийн Ажлын хэсгүүдийг байгуулж тодорхой ажлын чиглэлээр ажиллуулах, татан буулгах;

7.7.15. Ассоциацийн нэрийн өмнөөс төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, консорциум байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах;

7.7.16. Ассоциацийн бүхий л үйл ажиллагаанд хяналт тавих;

7.7.17. Ассоциацийг олон нийт, төрийн байгууллагатай холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх;

7.7.18. Ассоциацийн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө, санхүүжилт босгох үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах;

7.7.19. Ассоциацийг гадаад, дотоодын байгууллагад гишүүнээр элсүүлэх асуудлыг шийдэх;

7.7.20. Ассоциацийн өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг орон нутаг, дүүрэг болон гадаад улсад байгуулах;

7.7.21. Ассоциацийг гадаадын төсөл, хөтөлбөрт болон нийгэмд чиглэсэн хандив тусламжид хамруулах асуудлыг шийдэх, үр дүнд хяналт тавих;

7.7.22. Төрийн чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлэх, түншлэл байгуулж хамтран ажиллах асуудлыг шийдэж, түүнийг хөгжүүлэх;

7.7.23. Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх зарим чиг үүргийг Ерөнхийлөгчдийн зөвлөлд шилжүүлж болно.

7.7.24. Хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

7.8. Удирдах зөвлөлийн хурлын дэгийг Удирдах зөвлөлөөс тогтоон мөрдүүлнэ. Хурлын дэг нь энэхүү дүрмийн агуулгад нийцсэн, зохион байгуулалт, хурлын явцад үүсэх харилцааг нарийвчлан зохицуулж өгсөн байна.

7.9. Удирдах зөвлөлийн хурал нь гишүүдийн ердийн олонх оролцсоноор хүчинтэй болох ба хэлэлцсэн асуудлаар саналын эрхийн ердийн олонхоор гаргасан шийдвэр хүчин төгөлдөр болно. Удирдах зөвлөлийн хуралд биечлэн оролцох боломжгүй гишүүн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн төсөлд бичгээр болон цахимаар саналаа ирүүлсэн тохиолдолд түүнийг хуралд оролцсон гэж үзнэ.

7.10. Удирдах зөвлөлийн хурлаар гишүүдтэй холбоотой асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ.

7.11. Удирдах зөвлөлийн хурлыг Ерөнхийлөгч, түүний эзгүйд Тэргүүн дэд Ерөнхийлөгч даргална.

7.12. Зөвлөх гишүүн нь гишүүний татвар төлөхгүй бөгөөд Удирдах зөвлөлийн хуралд мэргэжлийн зөвлөгөө, санал, дүгнэлт өгч, саналын эрхгүйгээр оролцоно. Зөвлөх гишүүний тоог хязгаарлахгүй.

7.13. Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлаар Тогтоол гаргах ба түүнийг даргалагч гарын үсгээр баталгаажуулна. Удирдах зөвлөлийн хурлын тогтоол нь хурлаас гарсан хамтын шийдвэр тул цөөнх болсон гишүүд мөн хуралд оролцоогүй гишүүд түүнийг дагаж мөрдөнө.

7.14. Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэх асуудалд аль нэг гишүүн сонирхлын зөрчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж санал хураалтад оролцохгүй байж болно. Хурлыг даргалагч сонирхлын зөрчилтэй байвал даргалагчийг солино.

7.15. Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан тогтоол, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зөрчилтэй холбогдсон тайлбар, гарсан тогтоолын талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ. Гишүүн тайлбараа бичгээр гаргана.

7.16. Байнгын болон түр хороог Ассоциацийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нар удирдлагаар хангана. Ерөнхийлөгч нар Ассоциацийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын арга хэмжээ, ажлын чиглэлүүдийг тус бүрдээ хариуцаж ажиллана.

7.17. Удирдах зөвлөлийн гишүүд нь өөрийн мэдлэг, чадвар, ажлын туршлага, сонирхлын дагуу хэдэн ч хорооны бүрэлдэхүүнд ажиллаж болно.

7.18. Байнгын болон түр ажлын хэсгийн ажлын уялдаа, зохицуулалтыг Ерөнхийлөгчдийн зөвлөл нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

7.19. Ерөнхийлөгчдийн зөвлөл нь Удирдах зөвлөлийн хурлын чөлөөт цагт Удирдах зөвлөлөөс шилжүүлсэн эрх мэдлийг хэрэгжүүлж, олонхын саналаар хамтын шийдвэр гаргадаг Ассоциацийн бүтцийн нэгж байна.

7.20. Хороодын удирдлага нь ажлын зохион байгуулалт, ажлын төлөвлөгөөг боловсруулж Ерөнхийлөгчдийн зөвлөлөөр батлуулж, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, Ажлын албатай нягт хамтран ажиллах үүрэгтэй.

7.21. Түр хорооны бүрэлдэхүүнд Ассоциацийн жинхэнэ гишүүн, Зөвлөх гишүүн, салбарын мэргэжлийн бусад хүмүүсийг оролцуулж болно.

7.22. Удирдах зөвлөлийн хуралд Хяналтын зөвлөлийн гишүүн ажиглагчаар оролцоно.

7.23. Ассоциацийн гишүүнээр байгууллагаа төлөөлөн элссэн бол Удирдах зөвлөлийн сонгуульд байгууллагаа төлөөлж хэнийг сонгуулахаа тухайн байгууллага нь өөрөө шийдвэрлэж саналаа Удирдах зөвлөлд ирүүлнэ.

7.24. Тухайн үеийн нөхцөл шаардлагаас шалтгаалж, яаралтай шийдвэр гаргах зорилгоор Удирдах зөвлөл нь он-лайнаар хуралдан гишүүдээс цахимаар санал авч болох бөгөөд ийнхүү гаргасан Удирдах зөвлөлийн хурлын тогтоол, шийдвэр нь хүчин төгөлдөр байна.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ

8.1. Ассоциацийн Ерөнхийлөгчийг Удирдах зөвлөлийн хурлаас 3 жилийн хугацаатайгаар сонгох ба 1 /нэг/ удаа мөн хугацаагаар улираан сонгож болно.

8.2. Ассоциацийн Ерөнхийлөгч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

8.2.1. Ассоциацийг дотоодод ба гадаадад бүрэн эрхтэйгээр төлөөлөх, манлайлах;

8.2.2. Шаардлагатай тохиолдолд Чуулган, Удирдах зөвлөлийн Ээлжит бус хурлыг дүрэмд заасны дагуу зарлан хуралдуулах;

8.2.3. Удирдах зөвлөлийн хурлыг даргалах;

8.2.4. Ассоциацийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг жил бүр удирдан гаргуулах, өмч хөрөнгийг захиран зарцуулах;

8.2.5. Гүйцэтгэх захирлаар ажиллуулах хүнийг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, Гүйцэтгэх захиралтай Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд гэрээ байгуулах, Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, өөрчлөх асуудлыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах;

8.2.6. Удирдах зөвлөлөөс олгосон эрх мэдлийн хүрээнд Ерөнхийлөгчдийн зөвлөлийн тогтоол, Ерөнхийлөгчийн тушаалыг гаргах;

8.2.7. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн бусад байгууллагатай хамтран ажиллах;

8.2.8. Ассоциацийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түүнийг төлөөлж мэдэгдэл хийх.

8.3. Ассоциацийн Ерөнхийлөгчийг өөрийн санал болон Удирдах зөвлөлийн гишүүдийн 2/3 /гуравны хоёр/-ын саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хугацаанаас нь өмнө эрхийг түдгэлзүүлэх, эсвэл чөлөөлж болно.

8.4. Ассоциацийн Ерөнхийлөгч албан үүргээ хэрэгжүүлэх боломжгүй үед Тэргүүн дэд Ерөнхийлөгч орлон ажиллах ба санхүү, төсөв захиран зарцуулахаас бусад шийдвэрийг баталгаажуулах, Ассоциацийг төлөөлөн олон нийттэй харилцах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

8.5. Ассоциацийн Ерөнхийлөгчөөр сонгогдож ажилласан бүрэн эрхийн хугацаандаа идэвх санаачилга, үр дүнтэй ажиллаж Ассоциацийн хөгжилд зохих хувь нэмэр оруулсан Ерөнхийлөгч болон удирдах ажлын өндөр чадамжтай, мэргэжлийн, төр нийгмийн зүтгэлтэн хүмүүсийг “Хүндэт Ерөнхийлөгч”-өөр өргөмжилж, Ассоциацийг төлөөлж төр болоод олон нийттэй харилцах үйл ажиллагаанд оролцуулна. Хүндэт ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн хуралд зөвлөх эрхтэй оролцоно. Хүндэт ерөнхийлөгчийг Удирдах зөвлөлөөс батлана.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. АЖЛЫН АЛБА, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

9.1. Чуулган, Удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлж Ассоциацийн өдөр тутмын үйл ажиллагааг гардан явуулах үүрэгтэй орон тооны бүтэц болох Ажлын алба ажиллана.

9.2. Ажлын албыг Гүйцэтгэх захирал удирдах ба тэрээр орон тооны ажилтан байна.

9.3. Гүйцэтгэх захирал нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

9.3.1. Ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээний заалтуудын хүрээнд Ассоциацийг төлөөлөх;

9.3.2. Удирдах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.3.3. Ассоциацийн нэрийн өмнөөс иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцаж ажиллах;

9.3.4. Ажлын албаны хүний нөөцийг бүрдүүлэх, удирдах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх;

9.3.5. Ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээний хүрээнд Ассоциацийн өмч хөрөнгийг захиран зарцуулах;

9.3.6. Ажлын албаны орон тоо, бүтэц, цалингийн хэмжээ, үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг Удирдах зөвлөлөөр батлуулах;

9.3.7. Эрх хэмжээний хүрээнд Ажлын албаны үйл ажиллагааг хангах, ажилтныг томилох, чөлөөлөх, хэм хэмжээ тогтоосон журам, заавар гаргах зэрэг зорилгоор тушаал гаргах;

9.3.8. Сайн дурынхан болон олон нийттэй ажиллах;

9.3.9. Удирдах зөвлөлийг болон Ассоциацийн гишүүдийг мэдээллээр хангах;

9.3.10. Ерөнхийлөгчийн шууд удирдлаган дор ажиллаж, Удирдах зөвлөлийн гишүүд, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, Ерөнхийлөгчдийн зөвлөл, Ассоциацийн гишүүдтэй нягт хамтран ажиллах;

9.3.11. Ажлын албаны жилийн үйл ажиллагааны тайланг Удирдах зөвлөлд тайлагнаж, баталгаажсан тайлангаа дараа оны 02-р сарын 15-ны дотор төрийн эрх бүхий байгууллагад холбогдох баримт бичгийн хамт хүргүүлэх;

9.3.12. Санхүүгийн тайлан балансад жил бүр аудит хийлгэх, шилэн дансыг хөтлөх.

9.4. Гүйцэтгэх захирал нь бүрэн эрхийн хугацаа дууссан ч шинээр Гүйцэтгэх захирал томилогдох хүртэл албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх үүрэгтэй.

9.5. Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, өөрчлөх асуудлыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

АРАВДУГААР ЗҮЙЛ. ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

10.1. Хяналтын зөвлөлийг чуулганы хуралдаанаас 5 /тав/ гишүүний бүрэлдэхүүнтэй сонгон байгуулна.

10.2. Хяналтын зөвлөлийн даргыг Хяналтын зөвлөлийн гишүүдээс нууц санал хураалтаар олонхын саналаар сонгоно.

10.3. Хяналтын зөвлөл нь Ассоциацийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрмийн дагуу явагдаж байгаа эсэх, Удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтэд жилд 2 /хоёр/-оос доошгүй удаа шалгалт хийж дүгнэлт гаргаж, Гүйцэтгэх захиралд зөвлөмж хүргүүлнэ.

10.4. Хяналтын зөвлөл нь Ассоциацийн жилийн санхүүгийн тайланг шинжилж, дүгнэлтээ Удирдах зөвлөлд мэдээлж, Гүйцэтгэх захирлаас батлуулахаар оруулсан төсөв, төлөвлөгөөний талаар Удирдах зөвлөлд зөвлөмж хүргүүлнэ.

10.5. Хяналтын зөвлөл нь Ассоциацийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааны бодлого, бодлогын даган мөрдөлт, хөрөнгийн болон мэдээллийн аюулгүй ажиллагааны хамгаалалтыг судалж үнэлэлт өгнө.

10.6. Хяналтын зөвлөл нь Ассоциацийн хэрэгжүүлж байгаа төслүүд, байгуулсан гэрээнүүдийн үйл ажиллагаа, хэрэгжилттэй танилцаж, шаардлагатай бол холбогдох арга хэмжээг авахыг Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захиралд шаардлага болгоно.

10.7. Хяналтын зөвлөл нь Удирдах зөвлөлийн Дотоод хяналтын талаар гаргасан журам, дотоод хяналтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцаж холбогдох арга хэмжээг авахыг санал болгоно.

10.8. Хяналтын зөвлөл нь Ажлын албаны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, касс, эд хөрөнгийн тооцоо бүртгэлийг жилд 2 /хоёр/-оос доошгүй удаа шалгана. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, татвар хураамж төлөлт нь хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхийг шалгаж, гишүүдийн татвар төлөлт, хандивын байдал болон шаардлагатай гэж үзвэл Ассоциацийн гадаад харилцаатай холбогдол бүхий баримт бичгийг шалгаж зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлнэ.

10.9. Ассоциацийн гишүүд Хяналтын зөвлөлд тодорхой асуудлаар гомдол гаргаж болох бөгөөд уг асуудлыг Хяналтын зөвлөл яаралтай шалгаж, үр дүнг Удирдах зөвлөлд танилцуулна.

10.10. Хяналтын зөвлөлийн гишүүд шалгасан баримт бичиг, тайлан балансын нууцыг хадгална.

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН БАРИЛГЫН УЙЛДВЭРИЙН АССОЦИАЦИ ТББ
ХТА2020 ⊕ 8002511

10.11. Хяналтын зөвлөлийн гишүүд нь шалгалтын ажилтай холбогдсон материалыг Гүйцэтгэх захирлаас шаардаж гаргуулах, санхүүгийн аливаа шийдвэртэй холбоотой шаардлагатай баримт бичиг, нотолгоог шаардах эрхтэй.

10.12. Хяналтын зөвлөл нь 3 жилийн хугацаанд хийсэн тайлангаа нэгтгэж Удирдах зөвлөлд танилцуулж Ассоциацийн чуулганд тайлагнана.

10.13. Хяналтын зөвлөл нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх төсөвтэй байна. Төсвийг Ажлын албаны төсөвт суулган Удирдах зөвлөл батална.

10.14. Хяналтын зөвлөл нь эрхлэх үйл ажиллагаандаа удирдлага болгох Дотоод журамтай байна. Дотоод журмыг Удирдах зөвлөлийн хурлаар батална.

10.15. Хяналтын зөвлөл нь хяналтыг хэрэгжүүлэх явцдаа Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар зөвлөмж бичих, Ассоциацийн дүрэм, журам, бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалтууд нь хоорондоо зөрчилдөж үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэсэн бол түүнийг засаж залруулах шаардлагыг Чуулган, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захиралд хүргүүлж шаардлага тавих эрхтэй.

10.16. Хяналтын зөвлөл нь гишүүдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийн дагуу Ассоциацийн бүх төвшний удирдлагын ёс зүйн талаар Удирдах Зөвлөлд танилцуулж, шийдвэр гаргуулах эрхтэй.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙН САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТ

11.1. Ассоциацийн үндсэн хөрөнгийг зөвхөн Ассоциаци өөрөө эзэмших бөгөөд хөрөнгийг зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд Гүйцэтгэх захирал захиран зарцуулна.

11.2. Ассоциацийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

11.2.1. Гишүүний татвар;

11.2.2. Гишүүд болон гадаад, дотоодын иргэд, байгууллагаас өгсөн хандив;

11.2.3. Гадаад, дотоодын байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн ажлын төсөв;

11.2.4. Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;

11.2.5. Төсөл хэрэгжүүлэх зорилгоор Улсын төсөв, бусад байгууллагаас олгосон хөрөнгө;

11.2.6. Төрийн чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлэхтэй холбогдсон орлого;

11.2.7. Бусад эх үүсвэрийн орлого.

11.3. Ассоциаци нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

11.4. Ассоциацийн гишүүний жилийн татварын хэмжээ нь Ерөнхийлөгч 20 сая төгрөг, Тэргүүн дэд ерөнхийлөгч 15 сая төгрөг, Дэд ерөнхийлөгч 10 сая төгрөг, Удирдах зөвлөлийн гишүүн 5 сая төгрөг, энгийн гишүүн 2 сая төгрөг байна. Зөвлөх гишүүн ба ажиглагч гишүүн нь татвар төлөхгүй.

11.5. Ассоциаци нь орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх зэргээр ашиглахыг хориглоно.

11.6. Удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал болон Ажлын албаны ажилтан нь Ассоциацийн эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.7. Ассоциацийн дүрэмд заасан үйл ажиллагаанаас бусад зорилгоор эд хөрөнгө, мөнгийг бусдад хандивлахыг хориглоно.

11.8. Ассоциацийн Төгрөгийн болон Валютын дансны болон санхүүтэй холбогдох 1-р гарын үсгийг Гүйцэтгэх захирал зурна.

11.9. Гишүүн байгууллагуудын болон гишүүдийн татвар төлөх хугацааг Удирдах зөвлөлийн хурлаас тогтоох ба хандивын мөнгөнд хязгаар тогтоохгүй.

11.10. Ассоциаци нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдэд хандив өргөхгүй ба ийм үйл ажиллагааг хориглоно.

11.11. Ассоциацийн Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд нь өөрчлөгдвөл ажилласан хугацаанд ногдох гишүүнчлэлийн зэрэглэлийн татварыг төлнө.

11.12. Ассоциаци нь Эрсдэлийн нөөцийн сантай байх бөгөөд түүнд Ассоциацийн татварын орлого болон бусад орлогын 10 хувийг төвлөрүүлнэ.

11.13. Ассоциацийн хөрөнгө, санхүүгийн зарцуулалт ил тод, шилэн дансны зарчмаар байх бөгөөд Хяналтын зөвлөл, Удирдах зөвлөлийн гишүүдэд нээлттэй байна.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

12.1. Чуулганы хуралдааны шийдвэрээр шаардлагатай гэж үзвэл Ассоциаци нь бусад байгууллагатай нэгдэн нийлэх, эсвэл хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдаж болно.

12.2. Ассоциацийг татан буулгах шийдвэрийг Чуулганы хуралдаанаас гаргана. Чуулганд оролцсон гишүүдийн олонх зөвшөөрснөөр дараах үндэслэлээр татан буулгаж болно. Үүнд:

12.2.1. Дүрмийн зорилгоо хэрэгжүүлж дууссан;

12.2.2. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр;

12.2.3. Дүрмийн зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, хууль тогтоомж ноцтой болон удаа дараа зөрчсөний улмаас татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

12.3. Ассоциацийг татан буулгах шийдвэр гарсан тохиолдолд Хяналтын зөвлөлийн даргаар удирдуулан түүний санал болгосноор 5 /тав/ хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг Чуулганы хуралдаанаас томилно.

12.4. Ажлын хэсэг нь зохих төлбөр тооцоог барагдуулсны дараа түүний эзэмшлийн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх эсвэл зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулах зэргээр өмч хөрөнгийн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

12.5. Ажлын хэсэг нь татан буулгалтын ажлын тайлангаа нийт гишүүдэд мэдээлж, Улсын бүртгэлийн албанд бичгээр мэдэгдэнэ.

12.6. Шаардлагатай тохиолдолд Ажлын хэсгийн Дарга татан буулгах ажилд хөндлөнгийн холбогдох байгууллагыг оролцуулж болно.

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ
ХТА2020 ф 8002541

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. АССОЦИАЦИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ

13.1. Ассоциацийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах саналыг Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар Удирдах зөвлөл авч хэлэлцэнэ.

13.2. Удирдах зөвлөлийн авч хэлэлцсэн Ассоциацийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах саналыг Чуулганы хуралдаанаар хэлэлцэж Чуулганд оролцсон гишүүдийн олонхын саналаар дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн найруулж болно.

13.3. Батлагдсан дүрмийн шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлтийг тухай бүрд нь Улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал хариуцан гүйцэтгэнэ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. БУСАД ЗҮЙЛ

14.1. Ассоциацийн дүрэм, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн Гүйцэтгэх захирал нийт гишүүдэд мэдээлнэ.

14.2. Энэхүү дүрмийг батлагдсан өдрөөс эхлэн Ассоциацийн гишүүд, Ажлын албаны ажилтнууд нэгэн адил дагаж мөрдөнө.

14.3. Дүрмийн биелэлтэд Хяналтын зөвлөл хяналт тавина.

- - - 0 - - -